



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 449

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Мал эмнэлгийн ерөнхий газрын харьяа салбар нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 3 нэрийн нийт 59,124,800.00 (тавин есөн сая нэг зуун хорин дөрвөн мянга найман зуун) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий 3 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Ганзориг, Булган аймгийн Мал эмнэлгийн газрын дарга, “Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон Орон нутгийн өмчийн газрын төлөөлөгчийг оролцуулан үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримт, тээврийн хэрэгслийг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулсан тодорхойлолтын хамт 2021 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ
132001378

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА САЛБАР, НЭГЖИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

| Д/д | Автомашини марк, улсын дугаар, арлын дугаар | Үйлдвэрлэс эн, ашиглалта д орсон он | Тоо хэмжээ | Нийт гүйлт км | Нэг бүрийн үнэ | Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл | Худалдах доод үнэ | Салбар, нэгжийн нэр |
|-----------------|---|-------------------------------------|------------|---------------|----------------------|--|----------------------------|--|
| | | | | | | | | |
| 1 | УАЗ22096-003/фургон/ 69-80БУА Арлын дугаар:70406121 | 2006 | 1 | | 17,575,000.00 | 17,575,000.00 | 500,000.00 | Булган МЭГ |
| 2 | Форланд/Дук/ 65-11БУА Арлын дугаар:026962 | 2006 | 1 | | 21,511,800.00 | 21,511,800.00 | 2,000,000.00 | Булган МЭГ |
| 3 | Хьюндай Электра 50-55 УБЗ, КМНДУ41ВР7U210957 | 2001 | 1 | 244331 | 20,038,000.00 | 20,038,000.00 | 500,000.00 | Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуул алтын улсын лаборатори |
| | | | | | 59,124,800.00 | 59,124,800.00 | 3,000,000.00 | |
| Нийт дүн | | | | | | (тавин есөн сая нэг зуун хорин дөрвөн мянга найман зуун төгрөг) | (гурван сая төгрөг) | |